

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд,  
Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын  
2017 оны.....дугаар сарын .....-ны өдрийн .....  
дугаар хамтарсан тушаалын хавсралт

#### Услалтын систем эзэмших, ашиглах журам

1. Энэхүү журмын зорилго нь услалтын систем эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах замаар ашиглалтыг нь сайжруулан усалгаатай тариалангийн үр өгөөжийг дээшлүүлэхэд оршино.

2. Услалтын системийг ашиглахад оролцогч орон нутгийн төр, захиргааны байгууллага, ус ашиглагч ус хэрэглэгчийн хоорондын харилцааг энэхүү журмаар зохицуулна.

3. Усл

4. алтын системийн усан сан, усгы барилга байгууламж, тоног төхөөрөмжийг өмчлөгч, эзэмшигч байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь ус ашиглагч байна.

5. Услалтын системийн усан сан, усны барилга байгууламж, тоног төхөөрөмжийг хэд хэдэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэн өмчилж байгаа тохиолдолд усны эх үүсвэрээс ус авах толгойн барилга /шахуургын өртөө/, ус дамжуулах, түгээх гол суваг /хоолой/ эзэмшигч байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь ус ашиглагч байна.

6. Өмчлөгч байгууллага, аж ахуйн нэгж, иргэн нь услалтын системийнхээ усны барилга байгууламж, тоног төхөөрөмжийг өөр байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд гэрээгээр эзэмшүүлж болох бөгөөд энэхүү эзэмшигч нь ус ашиглагч болно.

7. Услалтын системийн услагдах талбайг эзэмшиж, усалгаатай хадлан бэлчээр тариалангийн үйлдвэрлэл эрхлэж буй бүх байгууллага, аж ахуйн нэгж, иргэн ын ус хэрэглэгч байна.

8. Услалтын системийн эзлэх нийт газар нь “Газрын тухай” хуулийн 10.1.1-д зааснаар газрын нэгдмэл сангийн хөдөө аж ахуйн газар гэсэн үндсэн ангилалд багтах бөгөөд түүнийг хадлан, бэлчээр, тариалан, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газар гэж ялгаж үзнэ.

#### Хоёр. Ус ашиглагч, хэрэглэгчийн харилцаа

1. Ус ашиглагч, хэрэглэгчийн хоорондын харилцааг таримал ургамлыг усаар хангах гэрээ /цаашид “гэрээ” гэх/-гээр зохицуулах

2. Ус ашиглагч нь услалтын системийн услагдах талбайн хил хязгаарт багтах тариалангийн талбайг эзэмших эрх бүхий байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй байгуулна.

3. Гэрээнд тариалах таримлын нэр, төрөл, тарих ба услах хугацаа, усны шаардагдах хэмжээ, гэрээг дүгнэх хугацаа, төлбөр тооцооны арга, талуудын эрх, үүрэг, хариуцлага, хохирол тооцох журам болон шаардлагатай гэж үзсэн бусад зүйлийг тусгана.

4. Ус ашиглагч болон ус хэрэглэгч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр таримал ургамлыг усаар хангах гэрээ байгуулахаас татгалзах эрхгүй.

5. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахтай холбогдсон харилцааг Иргэний хуулийн 178 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

#### Гурав. Ус ашиглагчийн эрх, үүрэг

1. Услалтын системийг ашиглалтанд хүлээн авсан буюу ашиглаж эхэлсэн үеэс эхлэн түүний хэвийн ажиллагааг хангах, илэрсэн эвдрэл, гэмтлийг тухай бүр арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

2. Услалтын системийн техникийн бичиг баримтыг иж бүрдүүлэн хувийн хэргийг хөтлөж, улсын бүртгэлд бүртгүүлэн үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, усан сан, усны барилга байгууламж, зам, шугам, сүлжээ, ойн зурвасны доорх газар эзэмших гэрчилгээ зэргийг авна.

3. “Усны тухай” хуулийн 25.1-д заасны дагуу ус ашиглах хүсэлтийг сум, дүүргийн Засаг даргад гаргаж шийдвэрлүүлэн 16.1.8 дахь заалтыг үндэслэн байгаль хамгаалагчтай ус ашиглах гэрээ байгуулж, эрхийн бичиг авна.

4. Ус хэрэглэгчийн гэрээнд заасан хэмжээний техникийн нөхцөлийн шаардлагад нийцсэн усаар зохих хугацаанд нь хангана.

5. Усаар үйлчлүүлсний хөлсийг ус хэрэглэгчээр төлүүлнэ.

6. Услалтын системийн усан сан, усны барилга байгууламж, тоног төхөөрөмжид технологийн шаардлагын дагуу хугацаат засвар, үйлчилгээ, шинэчлэлтийг хийж байнгын хэвийн ажиллагаатай байлгана.

7. Услалтын системийн усан сан, усны барилга байгууламж, тоног төхөөрөмжид их засвар, шинэчлэлт хийх шаардлагын улмаас тариалангийн талбайд ус өгөх боломжгүй болоход хүрвэл тариалалт эхлэхээс 3 сараас доошгүй хугацааны өмнө ус хэрэглэгчдэд энэ тухай албан ёсоор мэдэгдэнэ.

8. Осол эндэгдэл гарах, зайлашгүй урьдчилан сэргийлэх засвар, үйлчилгээ хийх тохиолдлоор тариалангийн усалгаа саатахад хүрвэл уг шалтгаан гарснаас хойш 24 цагийн дотор ус хэрэглэгчдэд мэдээлэл өгч, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

9. Услалтын системийн усан сан, усны барилга байгууламж, тоног төхөөрөмжийг усалгаанд бэлдэх, хадгалалтад тавих, усны хор хөнөөлөөс урьдчилан сэргийлэх, үерийн усыг өнгөрүүлэх, газрын хөрсийг давсжуулах, намагжуулахаас урьдчилан сэргийлэх зэрэг ашиглалтын бүхий л арга хэмжээг авч ажиллана.

10. Ус хэрэглэгчийн усалгааны сүлжээ, түр ба байнгын байрилга байгууламж, тоног төхөөрөмжид үзлэг шалгалт хийж, заавар зөвөлгөө өгөх ажлыг зохион байгуулна.

11. Ус хэрэглэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах учирсан хохирлоо төлүүлэхийг шаардана.

12. Услалтын системийн хэвийн ажилагааг хангах, усыг хуримтлуулах, хуваарилах, усалгаа хийх, усалгааны сүлжээнд гарсан гэмтлийг шуурхай арилгах үүрэг бүхий инженер-техникийн ажилтануудаас бүрдсэн ашиглалтын байнгын хэсгийг ажиллуулахын хамт техникийн болон аюулгүй ажиллагааны дүрмийг мөрдөж ажиллана.

13. Усалгааны график, хуваарь, дэглэм боловсруулж, сум дүүргийн Засаг даргаар батлалгаажуулан мөрдүүдэж болно.

14. Услалтын системийн зураг төслөөр баталгаажсан усан сан, усны барилга байгууламж, тоног төхөөрөмжийг дур мэдэн өөрчлөх, зориулалтын бус байдлаар ашиглах, эвдэх, сүйтгэх зэрэг зөрчил гаргасан этгээдээр учирсан хохирлыг төлүүлэх, барилга байгууламжийг нөхөн сэргээлгэх асуудлыг хуулийн байгууллага буюу тэдгээрийн төлөөлөгчидтэй хамтран шийдвэрлэнэ.

#### Дөрөв: Ус хэрэглэгчийн эрх үүрэг

1. Таримал ургамлыг усаар хангах гэээрнд заасан хэмжээний техникийн нөхцөлийн шаардлагад нийцсэн усаар зохих хугацаанд нь хангуулна.

2. Услалтын системийн усалгах талбайн хил хязгаарт хамаарах өөрийн эзэмшлийн тариалан, бэлчээр, хадлангийн талбайг жил бүр бүрэн ашиглах, ус ашиглагчаас авсан усаар өөрийн эзэмшлийн таримал ургамлын усалгааг зохих усалгааны горим, технологийн дагуу хугацаанд нь хийж арвин ургац авна.

3. Өөрийн эзэмшлийн талбайд ус өгөх зориулалтын салбар, суваг шуудуу /хоолой/ усны барилга байгууламж, усалгааны тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаатай байлгаж ус ашиглагчаас авсан усыг үр ашиггүй урсгаж талбайг намагжуулах, давсжуулах, хөрсийг угаах зэрэг үзэгдэл гаргахгүй байх.

4. “Усны тухай” хуулийн 31.1-д зааснаар таримал ургамлын усалгаанд авсан усныхаа үйлчилгээний хөлсийг тогтоосон хугацаанд нь ус ашиглагчид төлнө.

5. Ус ашиглагч гэрээнд заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд үйлчилгээний хөлсийг бүрэн буюу зарим хэсгийг нь төлхөөс татгалзах, хохиролоо нөхөн төлүүлэхээр ус ашиглагчаас нэхэмжилнэ.

6. Техникийн болон аюулгүй ажиллгааны дүрмийг мөрдөж ажиллана.
7. Услалтын системийн ашиглалтын талаар ус ашиглагчийн тавьсан шаардлага, зөвөлгөөг биелүүлнэ.
8. Услалтын системийн усан сан, усны барилга байгууламж, тоног төхөөрөмжийг дур мэдэн сэтлэх, өөрчлөх, эвдэх, ус хуваарилах барилгыг тохируулах хаалтыг ус ашиглагчийн зөвшөөрсөн хэмжээнээс илүү нээх, хаах, зүй бусаар ус авч ашиглах эрхгүй.

Тав: Сум, дүүргийн Засаг даргын эрх, үүрэг

1. Газрын тухай” хуулийн 21.4.3 заалтыг баримтлан услалтын системийн услагдах хадлан, бэлчээр, тариалангийн газрын зураг төсөлд заасан хил хязгаар, техникийн нөхцөлийн дагуу усалгаатай тариалан эрхлэх сонирхол бүхий байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд эзэмшүүлэх замаар услалтын системийн төслийн хүч чадалыг бүрэн ашиглуулах арга хэмжээ авна.

2. “Газрын тухай” хуулийн 27.6 заалтын дагуу услалтын системийн усан сан, усны барилга байгууламж, зам, шугам сүлжээ, ойн зурвас доорхи газрыг хөдөө аж ахуйн байрилга байгууламжийн дэвсгэр газарт хамааруулж ус ашиглагчид давуу эрхээр эзэмшүүлнэ.

3. Усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний дагуу услалтын системийн өмчлөгч, эзэмшигч байгууллага, аж ахуйн нэгж, иргэнтэй ус ашиглах гэрээ байгуулж гэрээний үндсэн дээр ус ашиглах зөвшөөрөл олгоно.

4. Ус ашиглагч, ус хэрэглэгчийн хооронд байгуулсан таримал ургамлыг усаар хангах гэрээний хэрэгжилтэнд хяналт тавина.

5. Ус хэрэглэгч нь услалтын системийн услагдах талбайн хил хязгаарт багтах эзэмшил газартаа усалгаатай тариалан эрхлээгүй байвал “Газрын тухай” хуулийн 40.1.6-д заасны дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгоно.

Зургаа: Хяналт, хариуцлага

1. Услалтын систем ашиглах журмын хэрэгжилтэд холбогдох мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагч, сум, дүүргийн Засаг дарга, байгаль хамгаалагч нар хяналт тавина.

2. Ус ашиглагч болон ус хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх бөгөөд уг шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдолоо гаргаж болно.

3. Энэхүү журмыг биелүүлэхгүй байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд Усны тухай, Барилгын тухай, Газрын тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.